



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



# Нүүдэлчин гар утасны программын сүүний урамшууллын хүсэлт илгээх заавар

Гар утасны апп татах холбоос:

Android



IOS Iphone



# 1. Нэвтрэх хуудас

“Дан систем нэвтрэх” товч дээр дарж Давхар танилт системээр дамжуулан нэвтрэх хуудас руу шилжинэ.

13:22

ХАРИУЦЛАГАТАЙ  
НҮҮДЭЛЧИД  
RESPONSIBLE  
NOMADS

Утасны дугаар \*

Нууц үг \*

Нэвтрэх


Дан систем нэвтрэх

## 2. Дан нэвтрэх хуудас


Нэг удаагийн нэвтрэлт болон Банкны эрхээр нэвтрэх аргыг хэрэглэх боломжтой.

Нийтлэг ашиглах боломжтой буюу “Банкны эрхээр нэвтрэх” товч дээр дарж хэрэглэгч та өөрийн ашигладаг интернет банкны эрхээр дамжуулан нэвтрэх юм.

# 3. Банкны эрхээр нэвтрэх




Та өөрийн интернет банкны **нэвтрэх нэр, нууц үгийг** оруулаад **нэвтрэх** товч дарах.



Таны “Регистрийн дугаар” -ийг хаан банкны интернет банк хэрэглэх эрхээр дамжуулан нэвтрэхийг “**Зөвшөөрөх**” товч дээр дарснаар цааш дамжуулах болно.

## 4. Иргэний мэдээлэл ашиглах хүлээн зөвшөөрөх

Нүүдэлчин систем нь таны регистрийн дугаараар дамжуулан хэрэглэгчийн мэдээллийг өгөх тухай зөвшөөрлийг **“Зөвшөөрөх”** товч дарснаар нэвтрэх болно.




# 5. Үйлчилгээний нөхцөлийг зөвшөөрөх



Монгол улсад “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай”, “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” хуулиудыг 2022 оны 5-р сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх болсонтой холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуйн яамны бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэхдээ хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахад дараах нөхцөлийг баримтлан, хэрэгжүүлнэ.



- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 6.1.1, 6.2.1
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 8.3, 8.4-т тус тус заасны дагуу Мэдээллийн эзний зөвшөөрлийг авна.

Та үйлчилгээний нөхцөлтэй танилцан “Зөвшөөрч байна” сонголтыг идэвхижүүлснээр программыг ашиглах боломжтой.




# 6. Сүүний урамшуулал цэсрүү орох

1. Нүүр хуудасны зүүн дээд буланд байрлах үндсэн цэсний товч дээр дарах
2. Сүүний урамшуулал цэс дээр дарах




# 7. Урамшууллын хүсэлт илгээх



Урамшууллын хүсэлт цэсэнд орсон ба

“Хүсэлт илгээх” товч дээр дарж урамшууллын хүсэлтээ илгээх цонхруу орно.



Хүсэлт илгээх гэж буй иргэн таны мэдээлэл хүсэлт гаргагч хэсэгт харагдана.

Урамшуулалд хамрагдах сарыг зурагт харагдаж буй **ОН САР** дээр дарснаар сонгож болно.

Хүсэлт гаргагч: Бат-Эрдэнэ овогтой Алтан-Өлзий (ЧК61081706)

Урамшуулалд хамрагдах сар: 2022 он 12 сар

Урамшууллын төрөл: Сүү

Мал эмнэлгийн гэрчилгээ: 13500 л

Ибаримт: 11529 л

Урамшуулалд хамрагдах боломжит дүн: 11529 л

Урамшуулалд хүлээн авах данс: [УДИРДАХ](#)

Данс сонгох

Өргөдөл:

Иргэн / хуулийн этгээд **Б.Алтан-Өлзий** нь Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоолын хавсралт "СҮҮ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР, ЦЕХЭД ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ШААРДЛАГАД НИЙЦСЭН МАЛЫН ТҮҮХИЙ СҮҮ НИЙЛҮҮЛСЭН МАЛЧИН, ЭРЧИМЖҮҮЛСЭН МАЛ АЖ АХУЙ ЭРХЛЭГЧДЭД МӨНГӨН УРАМШУУЛАЛ ОЛГОХ"-ын дагуу **11529** литр ундны сүүнд - тоот дансанд мөнгөн урамшуулал авах хүсэлтэй байна.


Урамшууллын хүсэлт автоматаар илгээх сар сонгох:

11 12 1 2 3

Зөвшөөрч байна




# 8. Урамшуулал хүлээн авах данс удирдах, шинээр бүртгэх




1. Урамшуулал хүлээн авах данс хэсэгт “Данс сонгох” дээр дарах ба таны данс гарч ирвэл дээр нь дарах.

Таны данс хоосон байвал **“УДИРДАХ”** гэсэн үгэн дээр дарах




2. Удирдах дээр дарснаар: “Бүртгэлтэй данс” цонх нээгдэх ба хэрэв танд данс байгаа бол зураг дээрх шиг харагдана.

(Хоосон бол нэмэх товч дээр дарах)



3. Нэмэх товч дарснаар: Шинээр данс нэмэх цонх нээгдэх ба

- Банкны нэр сонгох
  - Дансны дугаараа оруулах
  - Данс эзэмшигчийн нэрээ оруулаад
- Данс бүртгэх товч дээр дарснаар таны данс хадгалагдана.



# 9. Урамшуулал хүлээн авах данс Нэмсний дараа сонгох

Данс сонгох хэсэгт дарснаар та өмнөх хуудасны зааврын дагуу данс оруулсан бол таньд дараах зураг шиг сонголт гарч ирэх ба дээр нь дарж сонгоно.

Урамшууллын хүсэлт

Хүсэлт гаргагч: Бат-Эрдэнэ овогтой Алтан-Өлзий (ЧК61081706)

Урамшуулалд хамрагдах сар: 2022 он 12 сар

Урамшууллын төрөл: Сүү

Мал эмнэлгийн гэрчилгээ: 13500 Л

Ибаримт: 11529 Л

Урамшуулалд хамрагдах боломжит дүн: 11529 Л

Урамшуулалд хүлээн авах данс [УДИРДАХ](#)

Данс сонгох

**Өргөдөл:**

Иргэн / хуулийн этгээд **Б.Алтан-Өлзий** нь Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоолын хавсралт "СҮҮ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР, ЦЕХЭД ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ШААРДЛАГАД НИЙЦСЭН МАЛЫН ТҮҮХИЙ СҮҮ НИЙЛҮҮЛСЭН МАЛЧИН, ЭРЧИМЖҮҮЛСЭН МАЛ АЖ АХУЙ ЭРХЛЭГЧДЭД МӨНГӨН УРАМШУУЛАЛ ОЛГОХ"-ын дагуу 11529 литр ундны сүүнд - тоот дансанд мөнгөн урамшуулал авах хүсэлтэй байна.

Урамшууллын хүсэлт автоматаар илгээх сар сонгох:

11 12 1 2 3

Зөвшөөрч байна

Урамшуулалд хүлээн авах данс [УДИРДАХ](#)

ХААН БАНК - 5041447738

Өргөдөл:

Өргөдөл хэсэгт таны өмнөөс системээс үүсгэсэн өргөдлийн мэдээлэл харагдаж байна.

Та дараа саруудад өөрөө орж хүсэлт илгээхгүйгээр автоматаар буюу системээс хүсэлтээ илгээлгэж болно. Дараах зурагт харуулсан шиг автомат илгээх саруудыг идэвхижүүлээд, зөвшөөрөх сонгох.

Үүний тулд та сар бүр ибаримтаа шивэх, гарал үүслийн гэрчилгээ МЭГ авсан хэвээр байх хэрэгтэй.

Урамшууллын хүсэлт автоматаар илгээх сар сонгох:



11 12 1 2 3

Зөвшөөрч байна

# 10. Мал эмнэлгийн гэрчилгээ - Дэлгэрэнгүй лавлах


Мал эмнэлгийн гэрчилгээ хэсэгт харагдаж байгаа бүтээгдэхүүний тоо хэмжээ дээр дарснаар

Сонгосон сарын МЭГ хэмжээг **дэлгэрэнгүй харах**, **Шинэчлэх** гэсэн товч бүхий цонх нээгдэнэ.



Дэлгэрэнгүй харах дарснаар та МЭГ дэлгэрэнгүй үзэх цонх руу орох ба харгалзах сарыг сонгосноор гэрчилгээний дэлгэрэнгүй мэдээлэл харагдана.



Таны гэрчилгээ тоо хэмжээ хүлээн авагчийн мэдээлэл зөрүүтэй бол та гэрчилгээг үүсгэсэн малын эмчдээ хандана уу!



# 11. Ибаримтын- бүтээгдэхүүний Тоо хэмжээг дэлгэрэнгүй лавлах


Ибаримт хэсэгт харагдаж байгаа бүтээгдэхүүний тоо хэмжээ дээр дарснаар

Сонгосон сарын Ибаримтын хэмжээг **дэлгэрэнгүй харах**, **Шинэчлэх** гэсэн товч бүхий цонх нээгдэнэ.



Дэлгэрэнгүй харах дарснаар та Ибаримт дэлгэрэнгүй үзэх цонх руу орох ба харгалзах сарыг сонгосноор Ибаримтын дэлгэрэнгүй жагсаалтыг харна.

Таны ибаримтын тоо хэмжээ зөрүүтэй бол ибаримтыг үүсгэсэн үйлдвэртээ хандана уу!



# 12. Урамшууллын хүсэлтээ илгээх

## Хүсэлт илгээгдсэн

Урамшууллын хүсэлт

Мал эмнэлгийн гэрчилгээ: 13500 Л

Ибаримт: 11529 Л

Урамшуулалд хамрагдах боломжит дүн: 11529 Л

Урамшуулалд хүлээн авах данс [УДИРДАХ](#)

ХААН БАНК - 5041447738

Өргөдөл:

Иргэн / хуулийн этгээд **Б.Алтан-Өлзий** нь Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоолын хавсралт "СҮҮ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР, ЦЕХЭД ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ШААРДЛАГАД НИЙЦСЭН МАЛЫН ТҮҮХИЙ СҮҮ НИЙЛҮҮЛСЭН МАЛЧИН, ЭРЧИМЖҮҮЛСЭН МАЛ АЖ АХУЙ ЭРХЛЭГЧДЭД МӨНГӨН УРАМШУУЛАЛ ОЛГОХ"-ын дагуу **11529** литр ундны сүүнд **5041447738** тоот дансанд мөнгөн урамшуулал авах хүсэлтэй байна.

Урамшууллын хүсэлт автоматаар илгээх сар сонгох:

11 12 1 2 3

Зөвшөөрч байна

Буцах [Хүсэлт илгээх](#)

Та өмнөх хуудсууд дээр өгсөн зааварчилгааны дагуу бүх талбаруудыг нятглаад асуудалгүй бол

**“Хүсэлт илгээх”** товч дээр дарж урамшууллын хүсэлтээ илгээнэ.

Хүсэлт амжилттай илгээгдсэн бол доорх зураг дээр хүсэлтийн жагсаалт үүссэн байна.

Урамшуулал хүссэн бүтээгдэхүүний дүн хэсэгт таны хамрагдах боломжтой бүтээгдэхүүний дүн харагдаж байна.

Хүлээн аваагүй төлөвүүд нь дараах төлөвүүдэд шилжинэ.

**Төлөв:** Илгээгдээгүй  
Амжилттай илгээгдсэн  
Татгалзсан  
Олгогдсон

Урамшууллын хүсэлт

[Хүсэлт илгээх](#)

Бүтээгдэхүүн: Сүү  
Хүссэн дүн: 11529 л  
Олгогдсон дүн: 0  
Данс: ХААН БАНК - 5041447798  
Төлөв: Хүлээн аваагүй

# Түгээмэл асуулт

1. Мал эмнэлгийн гэрчилгээ 0 гээд гарахгүй эсвэл хэмжээ дутуу бол яах вэ?

Та өөрийн үйлчилгээ авдаг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид хандаж дараах мэдээллийг шалгуулна. Дараах шаардлага хангаагүй тохиолдолд системд татагдахгүй. Үүнд:

1. Хаанаас гэдэгт таны мэдээлэл буюу регистрийг зөв оруулсан эсэх
2. Хүлээн авагч байгууллага дээр тухайн онд сүүний урамшуулалд хамрагдах үйлдвэрийн регистрийн дугаараар зөв шивсэн эсэх
3. Бүтээгдэхүүний нэр төрлийг зөв оруулсан эсэх
4. Гэрчилгээний хүчинтэй хугацаа тухайн сардаа хүчинтэй байгаа эсэх
5. Баталгаажсан төлөвтэй гэрчилгээ эсэх

2. Ибаримтын дүн 0 гээд гарахгүй эсвэл хэмжээ дутуу бол яах вэ?

Таны үүсгэсэн татварын баримт ( ибаримт) нь дараах шаардлагыг хангасан байгаа эсэхийг шалгана. Дараах шаардлага хангаагүй тохиолдолд системд татагдахгүй. Үүнд:

1. Хүлээн авагч байгууллага дээр тухайн онд сүүний урамшуулалд хамрагдах үйлдвэрийн регистрийн дугаараар зөв шивсэн эсэх
2. Бүтээгдэхүүнийг зөв кодоо шивсэн эсэх
3. Тоо хэмжээ зөв сонгосон эсэх
4. Үүсгэсэн баримт тухайн сардаа бичигдсэн эсэх
5. Баримт хүчинтэй эсэх

2. А дансны бүртгэлгүй гээд хүсэлт илгээж болохгүй байвал яах вэ?

Таны мэдээлэл ХХААХҮЯ-ны Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэлгүй, эсвэл таны нэр дээр тухайн малын төрөл бүртгэгдээгүй байх магадлалтай тул та сум/дүүрэг хариуцсан Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэнд хандан мэдээллээ шалгуулна.

# Анхаарах



Зөвхөн шалгарсан үйлдвэрт сүү нийлүүлсэн байна.



Сар бүр борлуулсан сүүний төрөл, хэмжээгээр мал эмнэлгийн гэрчилгээг авсан байна.



Мал эмнэлгийн гэрчилгээ нь малын төрөл бүрээр байх ёстойг анхаарна уу.



Мал эмнэлгийн гэрчилгээний Хүлээн авагч тал нь жил бүрийн сүүний урамшуулалд сонгогдсон үйлдвэр байхыг анхаарна уу.



Сар бүр шалгарсан сүү боловсруулах үйлдвэр, цехэд борлуулсан бүтээгдэхүүний ибаримтыг тоо хэмжээ, бүтээгдэхүүний төрлийг зөв оруулан шивсэн байна.



Сар бүр шалгарсан сүү боловсруулах үйлдвэр, цехэд борлуулсан бүтээгдэхүүний ибаримтыг тоо хэмжээ, бүтээгдэхүүний төрлийг зөв оруулан шивсэн байна.



Сар бүр 1-10ны өдрийн хооронд өмнөх сарын урамшуулалд хамрагдах хүсэлтээ шаардлагатай.



Боловсруулах үйлдвэр, цех нь борлуулалтын мэдээг "Сүү бэлтгэлийн систем"-д оруулсан байх шаардлагатай.